



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

*дэлс* оны 06 сарын 28 өдөр

Дугаар 8/309

Улаанбаатар хот

**Б.Ундрахбаярт сахилгын  
шийтгэл ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмын 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн 20 дугаар хорооны улсын бүртгэгч Баасанжавын Ундрахбаяр нь Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Иргэн шилжин суурьшихдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж оршин суух газрынхаа /сум, хорооны/ улсын бүртгэгчид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ”, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 1.5.6 дахь заалтад “ИУБ маягтад иргэнээр гарын үсэг зуруулж, иргэний улсын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл үйлдэх” гэж заасныг зөрчиж шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтлөн албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь хяналтын улсын байцаагчийн 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 2324, 5 дугаар сарын 20-ны өдрийн 2658 тоот дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Б.Ундрахбаярт үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /Т.Булгантамир/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.



Б.БААСАНДОРЖ

571003059